



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/633

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Л.Доржбат (Засаг даргын Тамгын газрын даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Л.Баярсайхан (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Уянга (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Мөнхсаруул (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Дэлгэрмаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Л.Мягмармядаг (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Г.Оюунтунгалаг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Даариймаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ

хийж, үр дүнг үнэлэх удирдамж, аргачлалыг боловсруулан баталж, ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат) -т үүрэг болгосугай.

3. Сум, агентлагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, хийж үнэлэх ажлыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн удирдамж аргачлалын дагуу чанартай зохион байгуулж, дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Л.Доржбат), (Д.Даариймаа) нарт даалгасугай.



БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ
2023 оны 11 дүгээр сарын 27

УДИРДАМЖ

2023 оны 11 дүгээр сарын 20

Мандалговь хот

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх тухай

Зорилго: Монгол Улсын Засгийн газраас болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын баримт бичиг түүний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан туршлага судлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагууд

Хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 сарын 15-ны өдрийг дуустал

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг

НЭГ:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЧИГЛЭЛ

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- 1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- 1.2 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт

2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- 2.1 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн агентлагт хамааралтай заалтын хэрэгжилт
- 2.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 2.3. Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт

3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- 3.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ
- 3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ
- 3.3 Хөндлөнгийн үнэлгээ /Аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын ЗДТГ/

4. Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

4.1. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний агентлагийн даргын хүлээх үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил

ХОЁР: ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АРГАЧЛАЛ

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан журмуудыг баримтална.

Шалгуур үзүүлэлт тус бүр дээр авсан оноог хувьд шилжүүлэн үнэлгээний хувийг гаргана.

Ерөнхий үнэлгээг гаргахдаа 1, 2, 3, 4-р хэсгийн үнэлгээний дундаж хувиар тооцож гаргана.

ГУРАВ: БУСАД

Удирдамжийн 1,2,3 дугаар хэсгийн үзүүлэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдээс Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагийн 2023 оны ажлын явцын болон жилийн эцсийн тайлан, нотлох баримтад үндэслэн үнэлгээг аргачлалын дагуу өгнө.

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нар удирдамжийн 4 дүгээр хэсгийн үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа РР бэлтгэн ажлын хэсгийн өмнө 20 минутад багтааж танилцуулна. /Ажлын хэсэг үнэлгээний хуудсаар оноог өгнө/ Асуулт хариулт /10 мин/

Удирдамжид тусгагдсан үзүүлэлтийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн дүгнэж дуусган, агентлагуудын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг нэгтгэн, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн журмын дагуу 1, 2, 3 дугаар байр эзлүүлнэ.

БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГЫН
 АЛБАН УУРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ 
 2023 оны 12 дугаар сарын 12

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ, ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Үнэлэх үзүүлэлт		Үнэлгээ өгөх хэлтэс	Тайлан ирүүлэх хугацаа	Ирүүлэх баримт бичиг
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ					
1	1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	1.1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	XШҮХ	Жагсаалтын дагуу 2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор XШҮХ-д ирүүлэх	Нийтлэг Тусгайлан заасан заалтын хэрэгжилт
2	1.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	1.2.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор XШҮХ-т ирүүлэх	ЗДҮАХ-ийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт
3	1.3.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	1.3.1.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт	XШҮХ	2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор XШҮХ-т ирүүлэх	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайлан
Хоёр: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:					
1	2.1.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний үүрэг	2.1.1.Гэрээний үүргийн тухайн агентлагт хамааралтай арга хэмжээний хэрэгжилт	XШҮХ	Тайлан мэдээний хуваарийн дагуу	Тайлан
2	2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	2.2.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Харьяа хэлтсүүд	12 сарын сарын 05-ны дотор Харьяа хэлтэстээ ирүүлэх	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

		2.3.Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт	2.3.1.ХШҮХ-ээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлээд өгсөн зөвлөмж/	ХШҮХ	2023 оны 11 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Зөвлөмжийн хэрэгжилт
3		2.3.2.СӨГ-ийн шийдвэрлэлт		ТЗҮХ	4-р улирлын тайланг 12 дугаар сарын 20-ны дотор ТЗҮХ-д ирүүлэх	Тайлан
		2.3.3.Цахим шилжилт /байгууллагын гадаад болон дотоод цахим үйл ажиллагаа/		ТЗҮХ	Байгууллагын цахим хариуцсан албан хаагч нар ТЗҮХ-тэй ирж уулзан үнэлгээг 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор гаргуулах	ERP цахим систем болон байгууллагын албан ёсны цахим хуудас болон фэйж хуудаснаас шууд үнэлгээг гаргана.
		2.3.4.Эрх зүйн актын боловсруулалт		ХЭЗХ	-	ХЭЗХ-ийн үнэлгээг шууд хэрэглэнэ
		2.3.5.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах		ХЭЗХ	-	ХЭЗХ-ийн үнэлгээг шууд хэрэглэнэ
		2.3.6.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт		ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор ХЭЗХ-д ирүүлэх	Төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт
		2.3.7.Авлигын эсрэг Олон улсын өдрийг утган зохион байгуулсан ажлын тайлан, мэдээ		ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор ХЭЗХ-д ирүүлэх	Тайлан
		2.3.8.Байгууллагын албан хаагчдыг Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан байдал		НБХ	2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор НБХ-т ирүүлэх	Тайлан
		2.3.9.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судалж бүртгэх комисс байгуулж ажилласан эсэх		НБХ	2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор НБХ-т ирүүлэх	Тайлан
		2.3.10.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд тодорхой төсөв баталж зарцуулсан байдал		НБХ	2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор НБХ-т ирүүлэх	Тайлан

		2.3.11.Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал	НБХ	2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор НБХ-т ирүүлэх	Төлөвлөгөө, тайлан
		2.3.12.Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байдал	НБХ	-	Холбогдох хэлтсүүд үнэлгээг өгнө

Гурав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

1	3.1.Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, үр дүн	3.1.1.Мэдээллийн хуртээмжтэй байдлын үнэлгээ 3.1.2.Мэдээллийг хугацаандаа нийтэлсэн байдлын үнэлгээ 3.1.3.Мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээ 3.1.4.Мэдээллийн эх сурвалж	ТЗУХ	2023 оны 12 дугаар сарын 15-ны дотор ТЗУХ-д	98 шалгуур үзүүлэлтийг сайтад байршиулсан бол холбоос линкийг нотлох баримтын хамт
2	3.2.Шилэн дансны хөтлөлт	3.2.1.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ			
3	3.3.Хөндлөнгийн үнэлгээ	3.3.1.Агентлагийн үйл ажиллагааг дээд шатны байгууллага болон анхан шатанд ажиллаж буй байгууллагаар нь үнэлүүлэх	СХДАА	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор үнэлгээний дүнгийн нэгтгэлийг ХШҮХ-д ирүүлэх	Shilendans.gov.mn
					Санал асуулгыг ХШҮХ-ээс зохион байгуулна.

Дөрөв. Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

1	4.1.Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт, тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил	4.1.1.Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж ажиллана. 4.1.2.e-mongolia системийг иргэдэд сурталчлах, териийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллана. 4.1.3. Байгууллагын соёлыг нэвтрүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажиллана. 4.1.4.Байгууллагын гэрэлтүүлэг дотно, гадна камержуулалт 4.1.5. Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэгч байгууллагууд (Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд)-д. нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлнэ.	ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар	Тусгай хөтөлбөр, хуваарийн дагуу	Мэдээлэл бэлтгэн оролцно. /Мэдээллийг 20 минутад багтаан агентлагийн дарга танилцуулах бөгөөд мэдээлэл бэлтгэсэн байдал, илтгэх чадварыг үнэлнэ/
---	---	--	-----------------------------------	----------------------------------	---

		<p>4.1.6. Тухайн байгууллагын албан ёсны фейсбууک хуудсыг идэвхжүүлэх, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол оруулж хэвшэн байдал</p> <p>4.1.7. 2023 оныг аймгийн Засаг даргын захирамжаар "Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан хийсэн ажлын үр дун</p> <p>4.1.8. Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших</p> <p>4.1.9. Төрийн үйлчилгээг цахимжуулах болон иргэдэд хүргэх үйлчилгээний шат дамжлагыг бууруулсан талаарх арга туршлага</p> <p>4.1.10. Албан хаагчийг тогтвортой суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, Хүний нөөцийн хангарт, бүрдүүлэх чиглэлээр санаачилсан ажил</p> <p>4.1.11. Тухайн жилд зохион байгуулсан шинэлэг ажил Олон нийт рүү чиглэсэн, бусдад туршлага болохуйц 3 ажлыг танилцуулах</p>		
--	--	---	--	--

БАТЛАВ
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГЫН
 АЛБАН УУРЛИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ *Л.Доржбат*
 2023 оны 11 дугаар сарын 27

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АРГАЧЛАЛ

№	Үнэлэх үзүүлэлт		Үнэлгээ өгөх аргачлал	Өгвөл зохих оноо	Үнэлгээ өгөх хэлтэс	Хэлтсүүдийн үнэлгээ ирүүлэх хугацаа	Үнэлгээний мэдээллийн эх сурвалж
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ							
1	1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Нийтлэг болон тусгайлан заасан заалтын хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	XШҮХ	-	Тайлан
2	1.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	1.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Тухайн агентлагт хамааралтай заалтын хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	XШҮХ	-	Тайлан
3	1.3.Эдийн засаг нийгмийн үзүүлэлт	1.3.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	XШҮХ	-	Тайлан, статистик мэдээлэл
4	Дүн		30				
Хоёр: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ							
1	2.1.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх агаа хэмжээний	2.1.1.Агентлагт хамааралтай агаа хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Агентлагт хамааралтай заалтын дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	XШҮХ	-	Тайлан

	төлөвлөгөөний хэрэгжилт						
2	2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	2.2.1.Төлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	Харьяа хэлтсүүд	2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д дүнг ирүүлэх	Тайлан
	2.3.Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт	2.3.1.ХШҮХ-ээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлээд өгсөн зөвлөмж/ 10 оноо	Зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	8	ХШҮХ	2023 оны 11 дугаар сарын 10-ны дотор ХШҮХ-д ирүүлэх	Тайлан
			Хугацаандаа ирүүлсэн- 2 оноо, хугацаа хоцорч ирсэн-1 оноо, огт ирүүлээгүй -0 оноо	2		2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	ERP цахим систем
3		2.3.2.СӨГ-ийн шийдвэрлэлт	Шийдвэрлэлтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	TЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
	2.3.3.Цахим шилжилт /байгууллагын гадаад болон дотоод цахим үйл ажиллагаа		СӨГ-ийн тайлангийн хугацаа, чанар, шийдвэрлэлтийг харгалзан оноог өгнө.	10	TЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	ERP цахим систем болон байгууллагын албан ёсны цахим хуудас болон фэйж хуудас /2023.01.19 -ны өдрийн 03/98 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу/
			Дотоод үйл ажиллагаа цахимжсан эсэх	10	TЗУХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	ERP цахим систем болон байгууллагын албан ёсны цахим хуудас болон фэйж хуудас /2023.01.19 -ны өдрийн 03/98 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу/

		2.3.4. Эрх зүйн актын боловсруулалтыг хянаад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	Эрх бүхий албан тушаалтнуудаас батлагдаж буй тушаал шийдвэрийн үндэслэлийг зөв сонгож, батлагдсан хуваарийн дагуу Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж, зөвлөмжийг хэрэгжилтийн хувийг оноонд шилжүүлнэ.	10	ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Зөвлөмжийн хэрэгжилт
		2.3.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах	Тайлан, мэдээг хугацаандаа ирүүлсэн бол-10 оноо, Хугацаа хоцроосон буюу шаардлага хангаагүй бол 0-5 оноо, ирүүлээгүй бол – 0 оноо	10			Тайлан
		2.3.6. Авлига, ашиг сонирхлын зерчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт	Авлигын эсрэг ўйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	5	ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.3.7. Авлигын эсрэг Олон улсын өдрийг утган зохион байгуулсан ажлын тайлан, мэдээ ирүүлсэн байдал	/Хүргүүлсэн хүснэгтээр хугацаандаа ирүүлсэн бол-5 оноо/ ирүүлээгүй бол-0 оноо	5			Тайлан
		2.3.8. Байгууллагын албан хаагчдыг Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан байдал	Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувийг оноонд шилжүүлнэ.	10	НБХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.3.9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордолго судалж бүртгэх комисс байгуулж ажилласан эсэх	Комисс байгуулж ажилласан бол -5 оноо Үгүй бол -0	5	НБХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор	Тайлан

					XШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх		
		2.3.10.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд тодорхой төсөв баталж зарцуулсан байдал	Батлагдсан тесвийнхөө 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг зарцуулсан бол-5 оноо, 0.5-аас доош хэмжээний хөрөнгийг зарцуулсан бол-3 оноо, төсөв зарцуулаагүй бол-0	5	НБХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор XШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.3.11.Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	Хэрэгжилтийн дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	НБХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор XШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Тайлан
		2.3.12.Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд хамрагдсан байдал	Үнэлгээний дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	ТЗУХ НБХ СТСХ ХБТХОХ ХЭЗХ	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор XШҮХ-д ирүүлэх	Судалгаа, бүртгэл
4	Дүн		145				

Гурав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

1	3.1.Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, үр дүн	3.1.1.Мэдээллийн хүртээмжтэй байдлын үнэлгээ	Цахим хуудсанд байршсан бол 15, байршуулаагүй бол-0 Мэдээллийн самбарт байршуулсан бол-10 байршуулаагүй бол-0 Бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол-5, нийтлээгүй бол -0.	30	TЗУХ	2023 оны 12 дугаар сарын 28-ны дотор XШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Цахим хуудас Мэдээллийн самбар
		3.1.2.Мэдээллийг хугацаандаа нийтэлсэн байдлын үнэлгээ	Хугацаандаа нийтлэгдсэн бол -30, хугацаа хоцроож мэдээлсэн, шинэчилсэн	30	TЗУХ		Цахим хуудас Мэдээллийн самбар

			бол -10, нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол -0				
		3.1.3.Мэдээллийн бүрэн бүтэн байдлын үнэлгээ	Нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд мэдээлсэн бол -30 оноо, дутуу нийтэлсэн бол -15 оноо огт мэдээлээгүй бол -0	30	TЗУХ		Цахим хуудас
		3.1.4.Мэдээллийн эх сурвалж	нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол ХАНГАЛТАЙ буюу 30 оноо, мэдээллийн аль нэгийг нийтлээгүй бол ДУТУУ буюу 10 оноо, мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.	30	TЗУХ		Цахим хуудас
2	3.2.Шилэн дансны хөтлөлт	3.2.1.Шилэн дансны хэрэгжилт	Шилэн дансанд мэдээллийг 100 хувь байршуулсан бол-20 оноо, 90-99 хувь -10 оноо, 80-89 хувь -5 оноо	20	СХДАА	2023 оны 12 дугаар сарын 25-ны дотор ХШҮХ-д дүнгийн нэгтгэлийг ирүүлэх	Shilendans.gov.mn
3	3.3.Хөндлөнгийн үнэлгээ	3.3.1.Агентлагийн үйл ажиллагааг дээд шатны байгууллага болон анхан шатанд ажиллаж буй байгууллагаар нь үнэлүүлэх	Үнэлгээний дундаж хувийг оноонд шилжүүлнэ.	10	Аймгийн удирдлагууд, АЗДТГ-ын хэлтсүүд, Сумдын ЗДТГ	-	Урьдчилан бэлтгэсэн үнэлгээний хуудсаар авна.
4		Дүн	90				

Дөрөв. Тухайн жилд хийсэн онцлох ажлын үнэлгээ

1	4.1.Аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3-т заасан заалтын хэрэгжилт, шинэлэг ажил	4.1.1Гэрээний үүргийн биелэлт	Гэрээний үүргийн биелэлтийг ажлын хэсгийн үнэлгээний дундаж оноо	50	Ажлын хэсэг	Тусгай хөтөлбөр, хуваарийн дагуу	Бэлтгэсэн мэдээлэл	
		4.1.2.3 Шинэлэг ажил	Шинэлэг ажилд өгсөн ажлын хэсгийн үнэлгээний дундаж оноо	15				
		4.1.3.Илтгэлийн үнэлгээ	Илтгэл бэлтгэсэн байдал дундаж оноо	5				
			Илтгэх чадвар дундаж оноо	5				
2	Дүн		75					
3	Нийт оноо		340					

АГЕНТЛАГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

Үзүүлэлт		Хувь	Оноо
1	2	3	4
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2.Аймгийн Засаг даргын үл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 3.Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт Дундаж		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Яамдын сайд нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний агентлагт хамааралтай заалтын хэрэгжилт 2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 3.Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт Дундаж		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ 2.Шилэн дансны хетлөлт 3.Хөндлөнгийн үнэлгээ Дундаж		
Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээ	1.Гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээ Дундаж		
Ерөнхий үнэлгээ			

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС